



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2020 оны 11 сарын 23 өдөр

Дугаар А/221

Мандалговь

“Говь-Угтаал сумын ЗДТГ-ын албан хэрэгцээнд
бохир сорогч автомашин” нийлүүлэгчийг
сонгон шалгаруулах үнэлгээний
хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Говь-Угтаал сумын ЗДТГ-ын албан хэрэгцээнд бохир сорогч автомашин” нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Д.Даариймаа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн мэргэжилтэн)

Гишүүд: Э.Цэцэгчулуун (Иргэний төлөөлөл)
Ж.Элбэгзаяа (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэргэжилтэн)
Г.Жавзмаа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Б.Адъяасүрэн (Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн)

Хоёр. Үнэлгээний хороо тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Д.Даариймаа)-д даалгасугай.

Гурав. Тендер шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Б.Адъяасүрэн)-д үүрэг болгосугай.

ДАРГА ЦЭРДЭНЭСҮРЭН



482060875